



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/537

Чингис хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам” 2 дугаар зүйлийн 2.1.6 үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Норовлин сумын иргэн С.Энхбаатарт “Монгол Улсын аварга малчин” ном хэвлүүлэхэд зориулж 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012479